

# 5

## ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖИХ НЭГ ҮНДЭС НЬ МАЛ АЖ АХУЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

### П.Эрдэнэцэцэг

Монгол улс нь уламжлалт нүүдлийн мал аж ахуйн орон бөгөөд нүүдлийн соёл иргэншлээс хагас суурин, суурин хэлбэрт шилжиж буй өнөөгийн нөхцөлд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүний дотор мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ орчин үеийн хэрэгцээ шаардлагад тохируулан бэлтгэж, боловсруулж үйлдвэрлэх шаардлагатай. Одоо үед манай орны экспортод ашигт малтмал, уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт түлхүү хувийг эзэлж байгаа хэдий ч энэ нь экологийн хувьд хор хөнөөлтэй, шавхагдах нөөцтэй баялаг. Харин хөдөө аж ахуйн буюу мал аж ахуйн салбараас бэлтгэж, боловсруулах түүхий эд, бүтээгдэхүүн нь:

1. Нөхөн сэргээгдэх боломжтой, үл шавхагдах баялаг
2. Эртнээс уламжлагдан ирсэн өөрийн гэсэн арга технологитой.
3. Өнөөгийн дэлхий нийтийн чиг хандлага оригинал бүтээгдэхүүн хэрэглэх сонирхол өсч байна.

Иймд төр засгаас хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийн бэлтгэл, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд анхаарч дэмжих бодлогыг мэдэгдэхүйц өндөр түвшинд тавих төдийгүй өөрийн улсын хэрэгцээг хангаад улмаар гадагш нь экспортолж байсан боломж туршлагаа одоогийн байгаа нөхцөлдөө тохируулан шинжлэх ухааны үндэслэлтэй маш нарийн тооцоо судалгааны үндсэн дээр сэргээх шаардлагатай болоод байна. Манай улсын хувьд сүүлийн жилүүдэд бэлчээрийн даац хэтэрч байгаа тухай яригдах болсон бөгөөд тохиромжтой хэмжээ нь 25-30 сая малтай байх явдал гэж зарим судлаачид тогтоосон байдаг. Тухайн жилд бойжуулсан төлийн тоотой тэнцүү хэмжээний тоотой малыг мах бэлтгэлд нийлүүлж байх нь тохиромжтой.

Монгол улсын малын тоо толгой

Хүснэгт1

Үзүүлэлт	1990	2001	2002	2003	2004
НИЙТ МАЛЫН ТОО \мян.тол\	25800	26100	23897.6	25427.7	28027.9
ҮҮНЭЭС: ХОНЬ	15083	11937.3	10636.6	10756.4	11686.4
ҮҮНЭЭС: ЯМАА	5125.7	9591.3	9134.7	10652.7	12238
ҮЗҮҮЛЭЛТ	2005	2006	2007	2008	2009
НИЙТ МАЛЫН ТОО \мян.тол\	30398.8	34802.9	40263.8	43288.5	44023.9
ҮҮНЭЭС: ХОНЬ	12884.5	14815.1	16990.1	18362.3	19274.7
ҮҮНЭЭС: ЯМАА	13267.2	15451.7	18374.8	19969.4	19651.5

2010 онд малын нийт тоо ёмнөх оныхоос 11.3 сая буюу 25.7 хувиар буурсны дотор адуу 301.0 мянган толгойгоор буюу 13.5 хувь, үхэр 423.3 мянган толгойгоор буюу 16.3 хувь, тэмээ 7.5 мянган толгойгоор буюу 2.7 хувь, хонь 4.8 сая толгойгоор буюу 24.9 хувь, ямаа 5.8 сая толгойгоор буюу 29.4 хувиар тус тус буурчээ. Сүүлийн 10 жилд нийт малын тооны өсөлтийн 80 шахам хувийг ямаа эзэлж 1990 оныхоос 3.9 дахин өссөн нь зах зээлд ноолуурын хэрэгцээ, үнэ ихэссэнтэй холбоотой. Малчид ямаагаа өсгөх сонирхол их болсноор малын төрөл хоорондын тооны харьцаа эрс өөрчлөгдөж 1990 онд нийт малын дотор хонь 58.3 хувь, ямаа 19.8 хувь, үхэр 11.0 хувь, адуу 8.8 хувь, тэмээ 2.1 хувь байсан бол 2010 онд хонь 44.3 хувь, ямаа 42.5 хувь, үхэр 6.7 хувь, адуу 5.9 хувь, тэмээ 0.6 хувь эзлэх болов. Манай малчдын уламжлалт туршлагаас үзэхэд 100 богийн дотор 25-30 ямаа байлгаж байсныг ч анхаарах л зүйл.

Нэг ямаанд ноогдох хонины тоо

Хүснэгт2

Үзүүлэлт	1990	2001	2002	2003	2004	2005
Хонь/ямаа	2.9	1.3	1.2	1.01	0.96	0.97
Үзүүлэлт	2005	2006	2007	2008	2009	2010
Хонь/ямаа	0.97	0.96	0.93	0.92	0.98	1.04

Гэтэл нэг хотонд ноогдох хонь ямааны харьцааны 1990 он ба сүүлийн 10 жилийн үзүүлэлтээс үзвэл бог малын энэ харьцаа нь эерэг, серөг олон талтай. Эрдэмтэд мэргэжилтнүүд судалж зохистой харьцааг тогтоох нь чухал.

2009 онд манай мал сүргийн тоо толгой өсч 44023.9 саяд хүрч байгаа нь сайшаалтай боловч бэлчээрийн даац хэтрэх сөрөг нөлөөтэй. Иймээс цөөн тооны өндөр ашиг шим бүхий эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх шаардлага зайлшгүй тавигдаж байгааг харуулж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухаанжуулж тогтвортой хөгжлийг нь хэрэгжүүлэхийн тулд юуны өмнө малчдын хөдөлмөр зохион байгуулалтыг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор тавигдаад байна. Өнөөгийн байгаль цаг уурын хүнд нөхцөлд хүчин мөхөсдөж, хүн амын хүнсний өсөн нэмэгдсээр байгаа эрэлт хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй, мал аж ахуйн гаралтай экспортын бүтээгдэхүүнийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж чадахгүйд хүрээд байгаа жалгын нэг болж тархсан малчдын ганц өрхөд тулгуурласан аж ахуй зохион байгуулалтыг эрс өөрчилж хамтын хүч чармайлтад тулгуурласан эмчилгээ тэжээлийн бат бааз бүхий тохилог дулаан байраар хангагдсан, бэлчээрээ нарийн хуваариар зохистой ашигладаг малчдын хоршоо, фермерийн зохион байгуулалтад шилжүүлэх нь зүйтэй. Бэлчээрийн мал аж ахуйн мал маллагааны арга ажиллагааг хагас суурин маллагааны, ээлжийн отор бэлчээрийн аргатай бүтээлчээр хослуулж, бэлчээрийн мал аж ахуйг өөрийнх нь өвөрмөц онцлогтой уялдуулан эрчимжүүлэх хэрэгцээ буй болжээ. Ингэж суурин, хагас суурин маллагааны зохион байгуулалтад шилжүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг шинжлэх ухаанжуулах цогц асуудалд бүтээлчээр хандаж оны эхний нэг мал тухайн жилд бий болгох бүтээгдэхүүний хэмжээний өсөлтийг мал аж ахуйн тогтвортой хөгжлийн гол шалгуур үзүүлэлт болгон мөрдөж уг тогтвортой хөгжлийн явцыг түүгээр хэмжиж найдвартай хэрэгжүүлдэг, мал аж ахуйн мэргэжилтнүүдийг түүний бүтэц бүрэлдэхүүний идэвхитэй хэсэг болгосон тогтолцоог бүрдүүлэх, нөгөө талаар эрдэмтэд, мал аж ахуйн мэргэжилтнүүдийн

оюуны чадавх, хүч чармайлтыг үйлдвэрлэлтэй нягт холбон малын үүлдэр угсааг сайжруулж ашиг шимиийг нь эрс дээшлүүлэх, малын нөхөн үржихүй, селекци, үржлийн ажлыг хөтөлж буй уламжлалт аргыг боловсронгуй болгон, шинжлэх ухааны орчин үеийн дэвшилттэй аргууд, технологийг тууштай нэвтрүүлэн мал аж ахуйн чанартай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг эрс өсгөж, үндэсний үйлдвэрүүдээ чанартай түүхий эдээр хангах нийлүүлэлтийн сүлжээний тогтолцоог боловсронгуй болгох шаардлага өнөө үед нэн хурцаар тавигдаж байна.

Монгол мал нь эрс тэс уур амьсгал, бэлчээрийн маллагаанд маш сайн зохицсон, хөдөлмөр зарцуулалт харьцангуй бага шаарддаг, экологийн цэвэр бүтээгдэхүүн өгдөгөөрөө дэлхийн бусад оронд үржүүлдэг, суурин маллагааны малаас давуу талтай. Эрт дээр үеэс уламжлагдан ирсэн ардын селекцийн аргаар малынхаа чанар удам угсааг сайжруулж ирсэн нь бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд сонгомол арга байсан бөгөөд эдүгээ ч ач холбогдоо алдаагүйгээр барахгүй шинжлэх ухааны үндэстэй орчин үеийн үржил селекцийн ажлыг амжилттай явуулах суурь болсоор байна. Манай эрдэмтэд, мал аж ахуйн мэргжилтнүүд, малчидтайгаа хамтран 1960, 1970-аад оны үеэс олон жилийн шаргуу хөдөлмөрийнхөө үрээр “Сэлэнгэ” үхэр, “Орхон” хонь, “Ерөө” хонь, “Хангай” хонь “Говь гурван сайхан” ямаа зэрэг цэвэр үүлдрийн өндөр ашиг шимт сүрэг, “Үзэмчин” хонь, “Барга” хонь, “Баянцагаан” хонь, “Тулман хөхт” ямаа, “Хангайн хэцийн хүрэн” тэмээ, “Галбийн говийн улаан” тэмээ, “Дорнод монголын улаан” үхэр гэх мэт нутгийн шилмэл омгийн малуудыг бий болгосон ба гадаад улс орнуудаас олон төрлийн цэвэр үүлдрийн үхэр хонийг оруулж ирэн үржүүлж, эрлийзжүүлж, оросын болон Германы хар тарлан, сементаль зэрэг цэвэр үүлдрийн сүрэг, тэдгээрийн эрлийзүүдийг өсгөн үржүүлж, өндөр ашиг шимиийг нь ашиглан тодорхой амжилтанд хүрч байсан билээ. Тэдгээр ажлын зарим үр дүн өнөө үед ч үргэлжлэн ашиглагдаж, гол төлөв төвийн бүсийн нутагт уг өндөр ашиг шимтэй малуудын үр төлүүд дээр суурилсан эрчимжсэн мал аж ахуй эрхэлдэг үлгэр жишээ аж ахуй нэгж, фермерүүд үүсч, хөгжих аятайхан эхлэлүүд тавигдаж эхлээд байгааг бүх талаар дэмжиж мал аж ахуйн бүтээгдэхүүнийхээ үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Эрдэмтэд, мал аж ахуйн мэргэжилтнүүд, үндэсний үйлдвэрүүдийг орон нутаг дахь төр захиргааны шат шатны байгууллагууд мал аж ахуйн үйлдвэрлэлтэй ойртуулж технологийн шаардлагат түүхий эд бэлтгэл, түүний нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоход анхаарч, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй. Дээр хэлсэн өөрийн орны эрдэмтдийн шинээр бий болгосон тэр сайхан цэвэр үүлдрийн өндөр ашиг шимтэй малууд, тэдгээрийн эрлийзүүд одоо алга болоход дөхөж, тоо толгой нь ч цөөрөх боллоо. Манай орны аль ч бүс нутгийн шилмэл үүлдэр, омог хэвшлийг бататган сайжруулж, өсгөн үржүүлж тэднийг сайжруулагчаар ашиглах замаар нийт малын ашиг шимиийг үлэмжк нэмэгдүүлэх ихээхэн нөөц байгаа юм. Манай эрдэмтэд мэргэжилтнүүдийн идэвхитэй үйл ажиллагааны дунд тус орны байгаль цаг уурын болон бүс нутгийн нөхцөлд зохицсон шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгийн арвин ашиг шимт мал бий болсон юм. Зах зээлд шилжих явцад мал сүрэг хувьд очсон нь сайн боловч мал аж ахуйн менежмент алдагдаж олон арван жилийн турш оюун ухаан, хүч хөдөлмөрөө зарцуулан байж буй болгосон арвин ашиг шимт үүлдэр, омгийн малын тоо цөөрч, ялангуяа нарийн, нарийвтар ноост хонь, сүүний үхэр, ноос, ноолуурын ямаа, каракуль хонь тэдгээрийн эрлийз их цөөрсөн.

**Цэвэр эрлийз нутгийн омгийн болон сайжруулсан үүлдрийн малын тоо**

Төрөл	1990	2002	2003	2004	2005	2006	2007	2008	Хүснэгт1 2009	
									Хүснэгт1 2009	
Бүгд	506.0	645.9	1161.0	1211.3	1520.7	1783.0	1997.4	1794.7	1595.2	
Үхэр	80.5	25.3	15.7	26.5	21.7	30.2	33.1	28.3	35.5	
Хонь	333.6	504.2	975.3	1013.1	1205.2	1411.0	1574.7	1418.3	1331.7	
Ямаа	91.9	116.2	170.0	171.7	293.8	341.0	389.6	348.1	228.1	
<b>Эрлийз мал</b>										
Бүгд	1345.3	937.5	380.4	450.4	356.9	505.0	475.8	641.9	668.8	
Үхэр	171.9	91.6	57.9	53.5	55.5	62.3	67.9	78.8	78.8	
Хонь	837.4	545.5	68.1	73.7	53.9	57.7	59.9	98.9	111.9	
Ямаа	336.0	300.4	254.4	323.2	247.5	385.0	348.0	464.2	478.0	

	<b>Нутгийн шилмэл омог</b>									
Бүгд	1240.9	1115.2.4	572.8	708.4	697.4	774.3	745.6	721.0	829.5	
Тэмээ	5.0	5.2	5.2	5.3	7.3	8.7	9.4	10.8	12.0	
Адуу	-	36.4	19.0	21.4	16.5	25.3	27.7	19.3	31.2	
Үхэр	23.4	3.8	2.5	0.7	0.5	2.1	0.1	0.0	2.3	
Хонь	1198.0	564.7	65.5	81.6	113.0	103.9	65.2	63.3	142.6	
Ямаа	14.5	542.4	480.6	599.4	560	643.3	643.2	627.6	641.5	

Энэ хүснэгтээс цэвэр үүлдрийн малын тоо өсч байснаа 2007 оноос буураад байгаа статистик харагдаж байна. Харин зах зээлд шилжсэнээр он удаан жил манай орны нутаг усны байгаль, цаг уурын нөхцөлд дасан зохицож өндөр ашиг шимээ өгсөөр ирсэн, манай бэлчээрийн мал аж ахуйн тортон сүрэг гэж нэрлэж болохоор зарим төрлийн малын эрлийз болон нутгийн шилмэл омгийн малын тоо толгой тухайн төрлийн нийт малын доторх хувийн жин ч үлэмж доошилсоор байснаа 2006 оноос дахин сэргэж өсөж эхлээд байна. Тухайлбал: ХХI зуунтай 400-аадхан толгой болтлоо цөөрч золгосон мах ноосны хэвшлийн жигд нарийвтар ноост “Орхон” үүлдрийн хонь нь Хүнс хөдөө аж ахуйн яамны шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар 1961 онд батлагдсан Т. Аюурзана, Ж. Рааш, Ш. Дащцэрэн нарын бий болгосон бие томтой, алсын бэлчээрт оторлон идээшлэхэд зохицсон хүйтний улиралд тэсвэр сайтай. Үржлийн нас гүйцсэн хуцны амьдын жин дунджаар 84 кг, төлгөн хуцных 67.2 кг, эм хониних 57.5 кг, охин төлөгнийх 48 кг, махны нядалгааны гарц 49.4-53.3 хувь, эр хонины гулуузны дундаж жин 31.4 кг, хуцны ноосны гарц дунджаар 5.6 кг, төлгөн хуцных 5.1 кг, эм хониних 3.7 кг, охин төлөгнийх 3.4 кг, үүлдрийн дунджаар 3.3 кг жигд нарийвтар ноос өгдөг, төлөрхөг чанар сайтай. 100 эх тутмаас 114 хурга өгдөг, цэвэр үүлдрийн хонь юм. Сэлэнгэ, Дархан-уул аймгийн хэмжээнд нарийн нарийвтар ноост “Орхон”, “Хангай”, “Ерөө” хонини үүлдрийг хамгаалах, үржлийн ажлыг сайжруулах, ашиг шимиийг нэмэгдүүлэх, эрчимжүүлсэн хэлбэрийн мал аж ахуйн маллагааны шинэ хэв шинжтэй технологийг

мөрдүүлж, хэвшүүлэх “Сэлэнгэ хөгжлийн төсөл”-ийг Хүнс хөдөө аж ахуйн яам, мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд, Монголын нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн нийгэмлэг, Сэлэнгэ аймгийн Хөдөө аж ахуйн удирдах газар, Дархан уул аймгийн хөдөө аж ахуйн газар, Норвегийн тусlamжийн байгууллага хамтран 2001-оноос боловсруулан хэрэгжүүлжснээр мах ноосны хэвшлийн жигд нарийвтар ноост “Орхон” “Хангай”, “Ерөө” үүлдрийн хонины тоо нэмэгдлээ. Ер нь нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэх нэн шаардлагатай байна. Мэргэшсэн малчид, ажиллаж байгаа мал аж ахуйн мэргэжилтнүүд цөөрснөөс өндөр ашиг шимт малын генийн бүтцэд өөрчлөлт орж, ашиг шимиийн үзүүлэлт нь өмнөх үеэс буурсан үзүүлэлт гарч байна. Өргөн уудам нутагт ашиг шим багатай олон тооны малыг байгалийн аясыг дагаж маллаж амьдрах нь цаг агаарын эрсдэл, ган зудын давтамж жилээс жилд ихсэж байгаа өнөө үед тохиромжгүй. Эндээс эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх ялангуяа төвлөрсөн суурин газруудын орчимд байршуулах нь тохиромжтой байна. Иймд мал аж ахуйг бэлчээрийн даац, түүнийг ашиглах боломж, байгаль цаг уурын өөрчлөлттэй уялдан малын тоог харьцангуй хязгаартай өсгөх, чанар уудам угсааг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх тогтвортой хөгжүүлэх арга хэмжээг тууштай явуулж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж нэг малаас гарах бүтээгдэхүүний / мах, сүү, өндөг, ноос/ хэмжээг хэд дахин нэмэгдүүлж бага газар эзэмших бүтээмж ихтэй цөөн мал үржүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүнээр дотоодын үйлдэр, хүн амын хэрэгцээг хангах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжиж нэмэгдүүлэх явдал юм. Манай улсын хувьд мал аж ахуйгаа түшиглэсэн түүхий эд боловсруулдаг анхан шатны болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг жижиг үйлдвэрүүдийг хөдөө орон нутагт байгуулах ажлыг дэмжих хэрэгтэй байгаа бөгөөд түүхий эдийг орчин үеийн технологиор боловсруулж аль болох нэмүү өртөг шингээн экспортод гаргах хэрэгтэй

Монгол улсын хүн амын өсөлт, гадаад, дотоод зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан үзвэл ХХI зуунд үндэснийхээ үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэхийн тулд. малынхаа тоог зохистой хэмжээнд барьж бэлчээр, тэжээл, усан хангамж, бусад нөхцлийг бүрдүүлэх замаар ашиг шимийг нэмэгдүүлэх мах, сүү, ноос, ноолуур, арьс, шир бусад түүхий эдийг дотооддоо боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж улс орныхоо дотоод хэрэгцээг хангах, гадаад зах зээлд нийлүүлэх хэмжээг ихэсгэнэ. Мал аж ахуйн салбар нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 80 гаруй хувийг үйлдвэрлэдэг учраас мал аж ахуйн гаралтай түүхий эдийг малчдаас зах зээлийн дундаж үнээр худалдан авдаг, малчдад хэрэгцээт бараа таваарыг нийлүүлэх нийлүүлэлтийн сүлжээг бий болгох хэрэгтэй. Энд малчидтай холбоотой ажилладаг улсын үйлдвэр, хувийн хэвшлийнхийг өргөн оролцуулахад чиглэгдсэн эдийн засгийн урамшлын бодлогыг төрөөс авч хэрэгжүүлэх, малын гаралтай түүхий эдийг боловсруулах жижиг, дунд үйлдвэрүүдийг малчдад ойртуулж, орон нутагт зохистой байршуулах, малчин, түүхий эдийг худалдан авдаг үйлдвэр, аж ахуй нэгж, төр гурвын хамтын чармайлт, харилцан дэмжлэг шаардлагатай.

Манай хөдөө аж ахуйд улс орны бүхий л салбарт ажиллагсдын 45 хувь нь ажилладаг учраас энэ салбар ажлын байраар хангах, өрх гэр бүр ажлын байраар хангагдах бололцоо өргөн байдгаараа монгол улс өвөрмөц онцлогтой. Малын тоо 23,8-44,02 саяд хүрч, өсөж буурч байгаа нь мал аж ахуйн тогтвортой хөгжилд анхаарах шаардлагатайг баталж байна. Уур амьсгалын өөрчлөлт, манай орны нийгмийн хөгжлийн чиг хандлага, хүн амын суурьшил, зэрэгтэй уялдуулан

эрчимжсэн мал аж ахуйг тодорхой бүс нутагт зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлж, үндэсний үйлдвэрүүдийн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжсэнээр импортыг бууруулан, хүн амыг экологийн хувьд цэвэр бүтээгдэхүүнээр хангаж, экспортыг нэмэгдүүлэх боломжтой болно. Сүрэгт байвал зохих зохистой харьцааны голлох хувийг эзэлдэг хониноос авах ашиг шим, түүний дотроос хонины ноосны үнэ цэнэ бага түүхийгээр нь болон хагас боловсруулах нэрээр угаагаад шууд гадагш нь экспортолж байгаа нь алтыг нь аваад авдрыг нь хаяж байгаагийн тод жишээ билээ. Манай орны экспортын хувьд түүхий болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн голлож байна. Экспортын хэмжээг нэмэгдүүлэхдээ аль болох чанар, эрэлт хэрэгцээ сайтай нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зүйтэй. Манай хонины ноос, нэхий боловсруулах хэдэн үйлдвэрүүдийн эцсийн бүтээгдэхүүнүүд нь дотоод гадаадын хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц, тэдний таашаалд нийцсэн бүтээгдэхүүнүүд байдаг. Ноосны салбар 14,6 сая толгой хонины 18 мянган тонн ноосыг дотооддоо бүрэн ашиглах боломжтой гэсэн судалгаа байдаг. Энд зөвхөн төр, засгийн зөв зохион байгуулалт, дэмжлэг, оролцоо дутаж байна. Манай үйлдвэрүүд өөрийн түүхий эдийн нөөцөөр чанар сайтай даавуу, хивс, хөнжил бүтээлэг зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх нь зах зээлд өрсөлдөх нэг давуу тал болно.

Дэлхийн зах зээл дээр ноосоор үйлдвэрлэх бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, чанаржиж улмаар илүү тансаг, байгалийн гаралтай эдгээр хувцас хийх моод хүчээ авснаас нарийн ноос эрэлтэй байна. Гадаад орнуудад сүүлийн үед ургамлын болон амьтны гаралтай бүтээгдэхүүнээр болон ашиглалт багатай хялгаслаг түүхий эд болон бүдүүн ширхэгт хонины ноосоор барилгын дулаалгын материал хийх нь ихэсчээ. Англи, Австрали, Герман, Япон зэрэг улс ноосыг дээрх зориулалтаар бүтээгдэхүүн болгон ашиглаж байна. Ноосыг барилгын материалд ашиглахад халуун хүйтнийг сайн тусгаарладаг, уян хатан шинж чанартай учраас зай завсраар чигжих боломжтой. галд тэсвэртэй, бөх бат, эдэлгээ удаан, хөнгөн жинтэй зэрэг давуу талтай. Энэ нь 2009-2016 онуудад хэрэгжүүлэхээр боловсруулсан “**Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр**”-ийн дотоодын түүхий эд, нөөц боломжид тулгуурласан, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, дэвшилтэт технологи бүхий боловсруулах аж үйлдвэрийг хөгжүүлэн, олон тулгуурт эдийн засгийг бий болгох гэсэн зорилготой тохирч байна. Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн салбарын 2010 оны тэргүүлэх зорилт “Өрсөлдөх чадварыг сайжруулж, Бүтээмж, үр ашгийг дээшлүүльье” гэж байсан. Аливаа бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд шинжилгээ хийж, өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байгаа саад бэрхшээлүүд, тэдгээрийн арилжааны шийдлүүдийг тодорхойлж, нэмэгдсэн өртгийн сүлжээг хөгжүүлэх гэдэг нь тухайн пүссийн өрсөлдөх чадварыг сайжруулах явдал. Өртөг нэмэгдэх сүлжээний аль нэг түвшин дэх бэрхшээл нийт сүлжээний өрсөлдөх чадварыг бууруулдаг. Иймд түүхий эд бэлтгэлийн хангамж, үйлдвэрлэл үйл ажиллагаа, бэлэн бүтээгдэхүүний хангамж, маркетинг ба борлуулалт, түүний дараах үйлчилгээ гэсэн бүх шатуудыг хамарсан цогц арга хэмжээ авч, үе шат бүрт дүн шинжилгээ хийж, эцсийн боловсруулалт буюу бүтээгдэхүүний үнэлэмжийг дээшлүүлэх нь зүйтэй. Сүүлийн жилүүдэд улс орнуудын пүүс байгууллагууд бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулахад Michael Porter-ийн нэмэгдсэн өртгийн сүлжээний загварыг сонирхон судлах болсон байна. Иймээс үндэсний үйлдвэрүүдийг хөгжих, зах зээлд өрсөлдөх чадвараа дээшлүүлэхэд түүний дотор монгол малын сүргийн бүтцийн зохистой тоо хэмжээний ихэнх хувийг эзэлдэг хонины ноос боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэмэгдсэн өртгийн сүлжээнд шинжилгээ хийх саналтай байна.

## **Ном зүй**

1. "ХАА-н төлөвлөлт, үйлдвэрлэлийн удирдлагад хэрэглэх эдийн засаг - математик аргууд" Н. Логи УБ-1981
2. "Монголчуудын эдийн засгийн сэтгэлгээ" УБ-2008 ХҮДС-85
3. "Монгол улсын статистикийн эмхтгэл"-2005-2009 он
4. "Монгол улсын ХАА-н хөгжлийн зарим асуудал"-2007 он  
Ерөнхий Сайд асан, МУШУАкадемийн гишүүн, Доктор(Ph.D) Гавьяат агрономч Шаравын Гунгаадорж
5. "Ноолуурын нэмүү өртгийн шинжилгээ" 2010 оны 4 дүгээр сар
6. Мал аж ахуй-2005. УБ №2 Монголын мал зүйч үржүүлэгчдийн холбоо
7. Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр (2009-2016) Засгийн газрын 2009 оны 299 дүгээр тогтоолын хавсралт
8. "Ноос" дэд хөтөлбөр Монгол Улсын Засгийн тогтоол Дугаар 26
9. Martin L. leibowitz "Franchise Value" ISBN 0-471-64788-8
10. Porter, M.E. (1985) *Competitive Advantage*, Free Press, New York, 1985.
11. <http://www.nso.mn/>